

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн “Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОО-2024/22/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2024 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитор: С.Энхбаатар Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	9
3.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
4. Аудитын тайлан.....	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. Аудитын илрүүлэлт	13
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.08.14 № 887

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН "БАЙГАЛЬ
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА" ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Б.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймгийн "Байгаль хамгаалалтын захиргаа" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорнод аймгийн "Байгаль хамгаалалтын захиргаа" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

011021149

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29607240.00</u>	<u>23987540.80</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9700.00	10000.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9700.00	10000.80
3121	Төгрөг	9700.00	10000.80
31213	Арилжааны банк дахь харилцах	9700.00	10000.80
35	БАРАА МАТЕРИАЛ	29597540.00	23977540.00
354	Хангамжийн материал	29597540.00	23977540.00
35410	Бичиг хэргийн материал	145000.00	145000.00
35420	Аж ахуйн материал	29452540.00	22072540.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	660000.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	1100000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>151067168.66</u>	<u>153814338.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	151067168.66	153814338.54
392	Биет хөрөнгө	149567168.66	152614338.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115743395.13	115743395.13
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5483333.29	-17057672.89
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39690400.00	39690400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1778668.42	-6965659.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1815000.00	1815000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-419624.76	-601124.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	19990000.00
393	Биет бус хөрөнгө	1500000.00	1200000.00
39301	Програм хангамж	1500000.00	1500000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-300000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>180674408.66</u>	<u>177801879.34</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>0.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>180674408.66</u>	<u>177801879.34</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	180674408.66	177801879.34
512	Хуримтлагдсан үр дүн	180674408.66	177801879.34
51210	Өмнөх үеийн үр дүн	140488351.37	180674408.66
51220	Тайлант үеийн үр дүн	40186057.29	-2872529.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>180674408.66</u>	<u>177801879.34</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	180678253.95	184762631.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54820895.13	42640200.00
120	Нийтлэг татварын бус орлого	54820895.13	42640200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	54820895.13	42640200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9437500.00	22650200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45383395.13	19990000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	125857358.82	142122431.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	125857358.82	142122431.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	141057600.00	142122431.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-15200241.18	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	140492196.66	187635160.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	140492196.66	187635160.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140492196.66	187635160.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63523919.00	93210709.20
210101	Үндсэн цалин	63523919.00	93210709.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7759265.11	11342719.00
210201	Тэтгэврийн даатгал	7759265.11	11342719.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	635000.00	0.00
210304	Байрны түрээс	635000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12562450.00	15179407.00
210401	Бичиг хэрэг	391500.00	304200.00
210402	Тээвэр, шатахуун	8800000.00	6166118.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514800.00	514800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2856150.00	814289.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	7380000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	2016000.00
210604	Урсгал засвар	0.00	2016000.00
2107	Томилолт, зочны зардал	2336000.00	2968000.00
210702	Дотоод албан томилолт	2336000.00	2968000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	646247.58	45675495.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	44694178.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480000.00	360000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	64350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123147.58	111812.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	22000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	360000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	43100.00	47155.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	16000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53029314.97	17242830.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49625895.13	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3403419.84	17242830.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	40186057.29	-2872529.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	40186057.29	-2872529.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>135294858.82</u>	<u>164772631.00</u>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9437500.00	22650200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9437500.00	22650200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	125857358.82	142122431.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	125857358.82	142122431.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	141057600.00	142122431.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-15200241.18	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>140186316.82</u>	<u>164772330.20</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	140186316.82	164772330.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140186316.82	164772330.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63523919.00	93210709.20
210101	Үндсэн цалин	63523919.00	93210709.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7759265.11	11342719.00
210201	Тэтгэврийн даатгал	7759265.11	11342719.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	635000.00	0.00
210304	Байрны түрээс	635000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11719990.00	7799407.00
210401	Бичиг хэрэг	536500.00	304200.00
210402	Тээвэр, шатахуун	8800000.00	6166118.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514800.00	514800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1868690.00	814289.00
2105	Нормативт зардал	800000.00	1100000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800000.00	1100000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	2676000.00
210604	Урсгал засвар	0.00	2676000.00
2107	Томилолт, зочны зардал	2336000.00	2968000.00
210702	Дотоод албан томилолт	2336000.00	2968000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2146247.58	45675495.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	44694178.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480000.00	360000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	64350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123147.58	111812.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	22000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1500000.00	360000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	43100.00	47155.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	16000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51265895.13	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51265895.13	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-14328958.00</u>	<u>-22649899.20</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-14328958.00	-22649899.20

Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4901158.00	9700.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9700.00	10000.80

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	140,488,351.37	140,488,351.37	
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	140,488,351.37	140,488,351.37	
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	40,186,057.29	40,186,057.29	
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	180,674,408.66	180,674,408.66	
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	180,674,408.66	180,674,408.66	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	180,674,408.66	180,674,408.66	
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-2,872,529.32	-2,872,529.32	
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	177,801,879.34	177,801,879.34	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн “Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ нь аймгийн нутаг дэвсгэр дэх улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн экосистем, байгалийн унаган төрх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, тэдгээрийн тандалт судалгаа, хамгааллын ажлуудад үйл ажиллагаагаа чиглүүлэн явуулдаг, аймгийн Засаг даргын дэргэдэх байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд онцлох өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн Сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгээгүй, харин Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.9 сая төгрөгөөр буюу 1.6%-иар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9.7	10.0	0.3
Бараа материал	29,597.5	23,977.5	-5,620.0
Үндсэн хөрөнгө	151,067.2	153,814.3	2,747.1
Нийт хөрөнгө	180,674.4	177,801.8	-2,872.6
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	180,674.4	177,801.8	-2,872.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	180,674.4	177,801.8	-2,872.6

Дээрх хүснэгтээс харахад бараа материалын дансны үлдэгдэл 24.0 сая төгрөг болж 5.6 сая төгрөгөөр буурсан нь бараа материал акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 153.8 сая төгрөг болж 2.7 сая төгрөгөөр өссөн нь 19.9 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авч 17.2 сая төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу төрийн өмчит үйлдвэрийн газар нь тухайн оны санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж биелэлтийг хангах үүрэгтэй.

Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ-ын 2023 оны нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 141.1 сая төгрөгөөр баталсан байна. Тайлант оны батлагдсан төсвийг 21.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 162.9 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 142.1 сая төгрөгийн санхүүжилт авч, бусад орлогоор 22.6 сая төгрөгийг бүрдүүлж, 164.8 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 164.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1.9 сая төгрөг буюу 1.2 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь бусад орлогын зарцуулалттай холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн нэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Энхбаатар гүйцэтгэж, хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

“Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 187.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 1.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нэг авто тээврийн хэрэгсэл /суудлын автомашин/-д бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар болгон өөрчлөөгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ-ын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нэг зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	54,183.4	1	54,183.4	100
Нийт дүн	1	54,183.4	1	54,183.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Залруулсан алдаа:

- Төслийн хөрөнгөөр 5.0 сая төгрөгийн эд материал худалдан авч хашаа хийж барьсан ч данс бүртгэлд орлогоор тусгаагүй нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 24.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 24.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Төслийн хөрөнгөөс нэг ажилтны томилолтын зардалд 0.6 сая төгрөгийг олгосон ч тухайн ажилтан томилолтоор явсан нь нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5.2 Албан шаардлага

1. Тайлант оны эцэст эд хөрөнгийн тооллого хийсэн ч, 24.0 сая төгрөгийн бараа материалын тооллогыг баримтжуулж, баталгаажуулалгүй санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. “Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ нь санхүүгийн тайланг Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хуульд нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, нийтэд мэдээлнэ. Энэ ангилалд доор дурдсан аж ахуйн нэгж, байгууллагыг заавал хамруулна: 4.2.4.төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж,” Сангийн Сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нэг авто тээврийн хэрэгсэл /суудлын автомашин/-д бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар болгон хэрэглээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т "Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна" гэснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т нийцүүлэн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар болгон өөрчлөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төслийн хөрөнгөөр 5,000.0 мянган төгрөгийн эд материал худалдан авч хашаа хийж барьсан ч данс бүртгэлд орлогоор тусгаагүй.	1	5,000.0	-	-	1	5,000.0	1	5,000.0	-	-	-	-
Дүн	1	5,000.0			1	5,000.0	1	5,000.0	-	-	-	-

Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төслийн хөрөнгөөс нэг ажилтны томилолтын зардалд 568.0 мянган төгрөгийг олгосон ч тухайн ажилтан томилолтоор явсан нь нотлогдохгүй байна.	1	568.0	1	568.0								
Тайлант оны эцэст эд хөрөнгийн тооллого хийсэн ч, 23,977.5 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг баримтжуулж, баталгаажуулалгүйб	1	23,977.5			1	23,977.5						
Санхүүгийн тайланг Сангийн Сайдын аж ахуйн нэгжид зориулсан тушаалыг мөрдөөгүй байна.	1	0			1	0						
Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нэг авто тээврийн хэрэгсэл /суудлын автомашин/-д бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй.	1	0					1	0				
Дүн	4	24,545.5	1	568.0	2	23,977.5	1	0	0	0	0	0